



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/А80

Булган сум

Оны шилдэг хүүхэд шалгаруулах ажлын
хэсэг байгуулан арга хэмжээг зохион байгуулж,
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ХХ/09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Оны шилдэг хүүхэд шалгаруулах ажлын хэсгийг байгуулж, оны шилдэг хүүхэд шалгаруулах журмын дагуу 9 номинацийг шалгаруулах ажлыг зохион байгуулсугай.

2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, оны шилдэг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Оны шилдэг хүүхэд шалгаруулах ажлыг зохион байгуулахад шаардагдах 3,600,000 (гурван сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хүүхдийн эрхийг дээдлэн тэгш оролцоог ханган ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



6325011006

Булган Аймаг 2025 оны 12 сарын 18 өдөр
Хангайн Уул


Аймгийн Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 18-ны/ний өдрийн
А/А80 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Оны шилдэг хүүхэд шалгаруулах ажлын
хэсгийн бүрэлдэхүүн

- Дарга: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
- Гишүүд: С.Оюунзаяа (Хүүхэд, гэр бүлийн хөгжил,
хамгааллын газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч)
- Ц.Цолмонбаатар (Боловсролын газрын дарга)
- Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал,
залуучуудын газрын дарга)
- Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
- А.Гантөмөр (Байгаль орчны газрын дарга)
- Г.Отгонцэцэг (Хүүхэд, гэр бүлийн хөгжил,
хамгааллын газрын Нийгмийн ажилтан)
- Нарийн бичгийн дарга: Б.Мягмарсүрэн (Аймгийн Засаг даргын тамгын
газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

А/180
Аймгийн Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 18-ны/ний өдрийн
12 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ОНЫ ШИЛДЭГ ХҮҮХЭД ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

ОНЫ ШИЛДЭГ ХҮҮХЭД ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА						
Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хариуцах тал
1	2	3	4	5	6	7
1	Өргөмжлөл	Ш	10	70,000	700,000	Аймгийн Засаг даргын тамгын газар
2	Тууз	Ш	9+11=20	30,000	600,000	
3	Багийн амжилт мөнгөн шагнал	төгрөг	-	500,000	500,000	
4	Номинацийн эздэд мөнгөн шагнал	Төгрөг	9	100,000	900,000	
5	Оны шилдэг хүүхдүүдийн гарын бэлэг	Ш	20	45,000	900,000	
Нийт дүн – 3,600,000						

--oOo--